



БАТЛАВ

БАГШЫН МЭРГЭЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТЫН ЗАХИРАЛ Д.СҮРЭНЧИМЭГ

ЗӨВШӨӨРӨВ

БОМСТ НҮТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Э.ШИНЭЦЭЦЭГ



СУРГАЛТЫН ГЭРЭЭ

2018 оны 6 сарын 5-ны өдөр

№ 85

Улаанбаатар хот

Нэг талаас Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийг төлөөлж Дэд захирал О.Оюунтунгалаг (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "Байгаль орчны мэдээлэл сургалтын төв" НҮТББ-ыг төлөөлж Гүйцэтгэх захирал Э.Шинэцэцэг (цаашид "Гүйцэтгэгч" гэх, гэрээнд оролцогчдыг хамтад нь "Талууд" гэх) нар харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү сургалтын гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Захиалагч дотоодын боловсон хүчнээ чадавхижуулах зорилгын хүрээнд "ТХБ-ыг ЕБС-ийн сургалт-үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй" багшийн гарын авлагыг ашиглах, түгээн дэлгэрүүлэх арга зүйн хэлэлцүүлэг, болон "Тогтвортой хөгжил-процесийн хандлага" сургалтуудад байгууллагынхаа албан хаагчдыг хамруулахтай холбоотой харилцаа, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.
- 1.3. Гэрээний хугацаа 2018 оны 6 дугаар сарын 5-ны өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

ХОЁР. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Захиалагчийн эрх, үүрэг
 - 2.1.1. Гэрээгээр тохиролцсон үүргээ хугацаанд нь чанартай гүйцэтгэхийг шаардах
 - 2.1.2. Сургалтын төлбөрийг энэхүү гэрээний 3.2-д заасан хуваарийн дагуу хугацаанд нь шилжүүлэх
 - 2.1.3. Сургалтад гэрээгээр тохиролцсоны дагуу дотоодын албан хаагчдаа бүрэн хамруулах
- 2.2. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг
 - 2.2.1. Энэхүү гэрээний хавсралтаар баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтыг чанартай явуулах
 - 2.2.2. Гэрээгээр тохиролцсон үүргээ хугацаанд нь чанартай биелүүлэх

2.2.3. Сургалтын төлбөрийг энэхүү гэрээний 3.2-д заасан хуваарийн дагуу хугацаанд нь шилжүүлэхийг шаардах

ГУРАВ. ТӨЛБӨР ТӨӨЦӨӨ

2024.06.28

- 3.1. Сургалтын төлбөр нь нийт 8,130,000 (Дөрвөн сая таван зуун тавин мянган) төгрөг байх бөгөөд энэ дүнд аливаа татвар, шимтгэл багтсан болно.
- 3.2. Захиалагч сургалтын төлбөрийг гэрээ байгуулсан өдрөөс ажлын 10 хоногийн дотор Гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 499055202 тоот дансанд шилжүүлнэ.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

- 4.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлнө.

ТАВ. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Гэрээг хууль зүйн хувьд адил хүчинтэй 2 хувь үйлдэж тал тус бүр 1 хувийг хадгална.
- 6.2. Аливаа маргаантай асуудал гарвал талууд эвийн журмаар харилцан хэлэлцэж, бичгээр баталгаажуулах бөгөөд шийдвэрлэж чадахгүйд хүрвэл маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


.....


БАГШИЙН МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ
ИНСТИТУТИЙН ДЭД ЗАХИРАЛ

О.ОЮУНТУНГАЛАГ

Утас: 70140069

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, Багшийн хөгжлийн ордон

ГҮЙЦЭТГЭГЧ:



БОМСТ НҮТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Э.ШИНЭЦЭЦЭГ

Утас: 88111893

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж, Мидтаун оффис 503